



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоол, газрын дүрмийн 2.5.3 дахь заалт, Аялал жуулчлалын газрын албан хаагчдаас авсан саналын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга:

Ц.Энхтүвшин /Орлогч дарга/

Гишүүд:

В.Батчимэг /Бодлого

төлөвлөлтийн хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга:

Э.Мөнхзул /Жуулчны аюулгүй

байдал, тогтоол шийдвэрийн


биелэлт хариуцсан ахлах

мэргэжилтэн/

2. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Ёс зүйн хорооны дарга /Ц.Энхтүвшин/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2017 оны А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



1150500104